



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 43 нэрийн, нийт 1,300,138,332.03 (нэг тэрбум гурван зуун сая нэг зуун гучин найман мянга гурван зуун гучин хоёр төгрөг гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132230749
11-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 1 дугаар сарын 2-ны өдрийн
2025 оны 1 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Ашиглал танд орсон огноо	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1.Барилга байгууламж					
1	Хашаа /гаражийн, бетонон/	9,282,000.00	18.12.31	1	9,282,000.00
	Дүн			1	9,282,000.00
2.Тоног төхөөрөмж					
1	Хатуу диск /Hard disk drive /Dell Hard 2/	227,920.00	21.01.18	4	911,680.00
2	Серверын батарей /HP p4400 controller battery module,SN/	990,000.00	20.12.30	1	990,000.00
3	Пам /RAM Intel Max Mem 1600MHz/	1,060,000.00	20.12.30	1	1,060,000.00
4	Тохируулагч /Dell 32GB per SC4020 array 16GB per con/	1,400,000.00	20.12.30	1	1,400,000.00
5	Сервер /Raspberry Server Software програм/	346,500.00	20.11.18	5	1,732,500.00
6	Хатуу диск /Dell 300GB Fiber Channel 3.5/	900,000.00	20.12.30	2	1,800,000.00
7	Хатуу диск /HP 300GB 3.5 in Dual port 15k Spare 454/	956,200.00	20.12.30	2	1,912,400.00
8	Хатуу диск /HP 900GB SAs 10K, Spare 613922-001/	965,000.00	20.12.30	2	1,930,000.00
9	Хатуу диск /HP 300GB 2.5in SAS 5G DP 10k /les/	1,000,500.00	20.12.30	2	2,001,000.00
10	Хатуу диск /Hard drive /Dell 1.2 TB Hot-plug/	800,000.00	20.12.30	4	3,200,000.00
11	Дүрс хувиргагч /Media converter /CTC Union FMC- 1000M-SC20/	665,400.00	20.12.30	5	3,327,000.00
12	Хувиргагч /Media converte /CTC Union FMC-1000M- SC20/	665,400.00	20.12.30	5	3,327,000.00